# Алсын хараа - 2050

## Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

## 2022 оны жилийн эцэс

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2022 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Хоёр. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| 1 | 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. | 2.1.43. Нээлттэй боловсролын тогтолцоог бий болгон цахим болон зайн сургалтын нэгдсэн платформыг хөгжүүлэн бүх шатны боловсролын сургалтын байгууллагыг цахим хэрэглээнд бүрэн шилжүүлж, бүх насны суралцагч, иргэдэд зориулсан цахим сургалтын хөтөлбөр, агуулга боловсруулан түгээнэ. | 2020 - 2050 | - | - | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/473, А/221 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Улаанбаатар хот болон орон нутаг дахь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэн, хүлээлгэн өгсөн болно. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам нь зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн богино хугацааны мэргэшүүлэх сургалтын бодлого хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мэргэжлийн сургалтын бодлогын шинэчлэлт, өөрчлөлт цаашдын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан Монгол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн сургалтын байгууллагын удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлж тасралтгүй сайжруулалт, шинэчлэлт хийх хүрээнд Мэргэжлийн сургалтын байгууллагын удирдлага, мэдээллийн нэгдсэн систем www.mergejil.mn цахим системийг дараах модулийн хүрээнд хөгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.Үүнд:<br>- Олон нийтийн портал удирдлага<br>- Сургалтын хөтөлбөрийн удирдлага<br>- Суралцагчийн модуль<br>- Чадамжийн гэрчилгээний нэгдсэн сан+RPL<br>- Сургалтын байгууллагын бүртгэл +бүртгэлийн гэрчилгээний удирдлага<br>- Цахим төлбөрийн хэрэгслүүдийг нэвтрүүлэлт, төлбөрийн хяналтын модуль<br>- Багш, хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн модуль<br>- Мэргэжлийн зөвлөлийн бүртгэл, мэдээллийн модуль | 50 |
| 2 | 2.3. Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр | 2.3.1. Хүн амын төрөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын | 2020 - 2050 | | | Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар байгуулж, Монгол Улсад хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлыг ЭЗХЯ манлайлан зохион байгуулж ажилласан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүлийг төлөвшүүлнэ. | бодлого, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ. | | | | Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн хүрээнд 28 зорилго, 95 зорилт, 374 үйл ажиллагааг томьёолон тусгасан.<br>Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрт Хүн амын тогтвортой өсөлт, зохистой бүтцийг бүрдүүлэх, Хүнд ээлтэй, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг дээшлүүлэх, Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилж, үр ашгийг сайжруулахад тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан, шийдвэрлэх арга замуудад үндэслэн 6 зорилго, 20 зорилт, 48 үйл ажиллагааг томьёолон тусгасан. | |
| 3 | | 2.3.2. Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн, олон үндэстний гэр бүлээс гаралтай, хөгжлийн бэрхшээлтэй, шилжин суурьшигчид, эмзэг болон эрсдэлт бүлгийн гэр бүлийн хүүхдүүдийн тэгш эрх, аюулгүй байдлыг хангана. | 2020 - 2050 | - | - | 2022 оны Төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10.5-т "хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмыг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх аргачлалыг хүүхэд хамгааллын болон төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална" гэсэн нэмэлт орж батлагдсанаар хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг тооцох, санхүүжүүлэх эрх зүйн зохицуулалттай болсон. Уг заалтын дагуу "Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгаалал (ХНХ)-ын сайдын 2021 оны А/218 тушаал, "Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг төлөвлөх, санхүүжүүлэх аргачлал"-ыг ХНХ-ын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 хамтарсан тушаалаар, ХНХ-ын сайдын 2021 оны А/218 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журмыг тус тус батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>- Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, 20 орчим удаагийн санал авах уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, Засгийн газрын гишүүдээс санал авч сайжруулсан. Засгийн газрын бүрэлдэхүүн шинэчлэгдсэн тул үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Мөн хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс дахин санал авах бэлтгэл ажлыг эхлүүлсэн. | 70 |
| | | 2.3.3. Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг | 2020 - 2050 | | Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна. | Монгол Улсын дунд хугацааны Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 50 дугаар тушаалаар байгуулж, Монгол Улсад хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлыг ЭЗХЯ манлайлан зохион байгуулж ажилласан.<br>Хөгжлийн 6 зорилтот хөтөлбөрийн хүрээнд 28 зорилго, 95 зорилт, 374 үйл ажиллагааг томьёолон тусгасан.<br>Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрт Хүн амын тогтвортой өсөлт, зохистой бүтцийг бүрдүүлэх, Хүнд ээлтэй, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, Хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, Гэр бүлийн эрүүл, тогтвортой байдлыг дээшлүүлэх, Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилж, үр ашгийг сайжруулахад тулгамдаж буй асуудал, түүний шалтгаан, шийдвэрлэх арга замуудад үндэслэн 6 зорилго, 20 зорилт, 48 үйл ажиллагааг томьёолон тусгасан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | | хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна. | | | Хүүхэд харах үйлчилгээний журам, стандартыг шинэчлэн батлуулж, хүүхэд хүлээж авах бэлтгэлийг хангасан байна. | 2022 оны 02 дугаар сараас Хүүхэд харах үйлчилгээ ХНХЯ-ны эрхлэх асуудалд шилжин ирсэнтэй холбогдуулан МУЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 97 тоот тогтоолоор “Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох” журам, ХНХ-ын сайдын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/38 тоот тушаалаар “Хүүхэд харагч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр”, ХНХ-ын сайдын 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/151 дугаар “Журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам” шинэчлэн батлагдсан.<br>Монгол Улсын төсвөөс 2022 оны төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээний зардалд 2.1 тэрбум төгрөгийг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад батлагдсан бөгөөд энэ хүрээнд 2022 онд 1894 энгийн хүүхэд, 106 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдах тооцооллыг хийсэн.<br>2/ 2022-02-28-ны өдрийн А/38 тоот “Хүүхэд харагч бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөр”-ийн хүрээнд ГБХЗХГ-ын даргын 2022-05-06-ны өдрийн А/115 тоот “Хүүхэд харагч бэлтгэх сургалтыг зохион байгуулах тухай” тушаалын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Монголын хүүхдийн эрхийн үндэсний төвийн 12 мэргэжилтэнг Хүүхэд харах үйлчилгээний Үндэсний сургагч багшийн сургалтад хамруулж, гэрчилгээ олголоо. Хүүхэд харагчдыг чадавхижуулах сургалтыг Монголын Хүүхдийн эрхийн үндэсний төв НҮТББ-тай гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 2022-05-25-аас 07 сарын 10-ны хугацаанд зохион байгуулж байна. 15 аймаг, 7 дүүргийн 486 хүүхэд харагч нарт хүүхдийн эрх, хамгаалал, хүүхдийн хоол тэжээл, эрүүл ахуй, ариун цэвэр, хүүхдийн асаргаа сувилал, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлээр сургалт зохион байгуулсан.<br>3/ “Нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын 6 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2022 оны А/145, А/261 дугаар хамтарсан тушаал баталж, нийслэлийн цэцэрлэгийн хүртээмж багатай Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт хүүхэд харах үйлчилгээг өргөжүүлж, 2-3 настай 2000 хүүхдийг нэмж авахаар шийдвэрлэсэн. Шинээр 320 хүүхэд харагч 5 өдрийн сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн.<br><br>2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хүүхэд харах үйлчилгээнд нийт 2239 хүүхэд үйлчлүүлсэн байна.<br>Хүүхэд харах үйлчилгээний төв болон цэцэрлэгийн хүүхдийн даврхардлыг шалган 303.460.806.4 төгрөгийн санхүүжилтийг төвүүдэд олгосон. Үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар арга зүйн дэмжлэг үзүүлж 10 зөрчил илрүүлж асуудлыг шийдсэн. | 100 |
| | | | | 1,5 тэрбум | Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийн 70 хувьд урьдчилан | 1/ 2022 онд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээг 77967 хүүхдэд, урьдчилан сэргийлэх үйлчилгээг 318900 хүүхдэд үзүүлсэн байна. Үүнд: | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сэргийлэх үйлчилгээ, хамгаалал шаардлагатай хүүхдэд хариу үйлчилгээг 100 хувь үзүүлсэн байна. | - Эрсдлийн программд бүртгэлтэй 14,207 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. Харьяаллаар нь авч үзвэл: орон нутагт 10,842, нийслэлд 3,365 байна.<br>- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмын дагуу 3625 хүүхдэд шуурхай тусламжийн үйлчилгээ, 18843 хүүхдэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ, 131906 хүүхдэд хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлсэн.<br>- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хуульд заасан чиг үүргийн хүрээнд ажиллаж, нийт 1284 хүүхэд үйлчилгээ авсан.<br>- Хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой нийт 116 гомдол мэдээллийг хүлээн авч, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу 110 зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэж 32,9 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна. Хүүхдийн эрхийн зөрчлийн 6 хэргийг шалгаж байна.<br>- Хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн 21 байгууллагын 30 төвд 0-21 насны 974 хүүхэд, 19-21 насны 86 залуус амьдарч байна.<br>- Хараа хяналтгүй 63 хүүхэд, хөдөлмөр эрхлэгч 59 хүүхэд, эцэг эхийн хараа хяналт сул 122 хүүхдэд үйлчилгээ үзүүлж, хяналт тавин ажилласан байна.<br>- Хүүхэд, өсвөр үеийхэнд цагийг үр дүнтэй бүтээлч өнгөрүүлэх чиглэлээр 144 арга хэмжээнд 83,762 хүүхэд хамрагдсан.<br>- Хүүхдийг болзошгүй эрсдэлээс болон /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр 588 удаагийн арга хэмжээнд 96528 хүүхэд, 105352 насанд хүрэгч, хүүхэд, гэр бүлд чиглэсэн нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг 27715 хүүхдэд үзүүлсэн байна.<br>2/ 2022 оны эхний 11 сарын байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд 99204 дуудлага ирсний 58058 буюу 58.5 хувь нь зорилтот дуудлага эзэлж байна. Нийт дуудлагын 8.2 хувь буюу 8174 дуудлагыг аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, сум, хорооны хамтарсан багт шилжүүлсэн байна. Кейс шийдвэрлэлт 66.7 хувьтай байна. Үлдсэн 33.3 хувь буюу 2722 нь хяналтанд хүүхэд хамгааллын үйлчилгээ авч байна. | |
| | | | | 221,8 сая | Гэр бүл, хүүхэд, залуучууд ахмад настны хөгжлийн цогц төвийн үйлчилгээг нийт хүн амын 10-с доошгүй хувьд хүргэсэн байна. | - Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 5 сум (Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Номгон, Булган)-д ажиллаж, амьдрах ухааны сургалт, сонирхлын клуб, зөвлөлийг ажиллуулах, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ, тусламж, гэр бүлийн зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээнд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг хамруулдаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 450 мянга гаруй залуучууд буюу нийт залуучуудын 45 хувьд хөгжлийн үйлчилгээг хүргэсэн. Мөн Ховд аймгийн Манхан сум, Баян-Өлгий аймгийн Сагсай сум, Завхан аймгийн Их-Уул суманд Залуучуудын хөгжлийн төвийг шинээр байгуулаад байна.<br><br>- Аймаг, нийслэл, дүүргүүдэд нийт 27 "Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв" ажиллаж, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжлийн эерэг арга эзэмшүүлэх, угийн бичиг хөтлөх, зан үйлд нөлөөлөх чиглэлээр сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд 2022 онд урьдчилсан байдлаар /10-р сарын байдлаар/ нийт 96438 иргэнийг хамруулж, эрүүл мэнд, халамж, хөдөлмөр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхлэлт, иргэний бүртгэл зэрэг нийгмийн суурь үйлчилгээнд 1018 иргэнийг холбон зуучилсан. Төвөөр дамжуулан нийт 4572 иргэнд зөвлөн туслах үйлчилгээг үзүүлснээс 2085 хүүхэд, 2487 насанд хүрэгчдийг хамруулж, сэтгэл зүйн ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөөг 3261 иргэн, эрх зүйн зөвлөгөөг 2684 иргэнд өгсөн.<br>2022 онд 38 хүүхдийн зусланд 34062 хүүхэд, Хүүхдийн ордон, төвөөр үзүүлэх хөгжлийн үйлчилгээнд 56523 хүүхэд хамрагдсан байна. | |
| 5 | | 2.3.4. Орлогын тэгш бус байдлыг багасган нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэж, нийгмийн зорилтот болон ялгаатай бүлгүүдийн эрх, тэгш оролцоог хангана. | 2020 - 2050 | | Эдийн засаг, хөгжлийн яам нь “Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулна. | Эдийн засан, хөгжлийн яам нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийг боловсруулан 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-д өргөн мэдүүлэхээр болсон. Уг хөтөлбөрийн хүрээнд Орлогын тэгш бус байдлыг багасган нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэж, нийгмийн зорилтот болон ялгаатай бүлгүүдийн эрх, тэгш оролцоог хангах асуудлыг тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. | 90 |
| 6 | | 2.3.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ. | 2020 - 2050 | 12.6 тэрбум Дэлхийн банк | 20.0 тэрбум | Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд журамд жижиг зээлийг 36 хүртэл сарын хугацаатай олгох, үндсэн зээлээс 6 сарын хугацаатай чөлөөлөх, жижиг зээлийн хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөг байхаар шинэчлэн баталсан.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих жижиг зээлийг 2019 оноос эхлэн бүх орон нутагт салбартай Төрийн банк болон Хаан банкаар дамжуулан олгож байгаа бөгөөд 2021 онд КОВИД-19 цар тахлын улмаас үүсээд буй эдийн засгийн хүндрэлтэй байдлыг харгалзан зээлийн эхний саруудад хүүг 7.56 хувиар тооцож, 6 сар хүртэл хугацаагаар зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх зэрэг хөнгөлөлтийг үзүүлсэн. Тухайн жилд нийт 1301 иргэнд 11,6 тэрбум төгрөгийн зээлийг олгож, нийт 2499 ажлын байрыг бий болгож, хадгалахад дэмжлэг үзүүлсэн байна.<br>2022 оны 12 дугаар сарын байдлаар “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг олгож үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа бөгөөд нийт 2200 иргэнд, 14.5 тэрбум төгрөгийн жижиг зээлийг олгож 2300 ажлын байр бий болгож, хадгалахад дэмжлэг үзүүлсэн бөгөөд үүнээс 1300 гаруй нь эмэгтэйчүүд эзэлж байна. | 100 |
| 7 | | 2.3.6. Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх | 2020 - 2050 | Дэлхийн банкны 4500$ | Аргачлалыг батлуулсан байна. | “Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал”-ыг боловсруулах, батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ХНХ-ын сайд, ҮСХ-ны даргын 2020 оны 11 сард А/225, А/60 тоот хамтарсан тушаалаар байгуулан, аргачлалыг шинэчлэн боловсруулж ҮСХ-ны арга зүйн байнгын зөвлөл болон даргын зөвлөлөөр хэлэлцүүлж, ҮСХ-ны дарга, ХНХ-ын сайдын 2022 оны А/84, А/89 хамтарсан тушаал батлуулав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нийгмийн халамжийн тусламж, дэмжлэгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | Улсын хэмжээнд өрхийн амьжиргааны түвшнээс доогуур орлоготой өрхөөс судалгааг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн нэгдсэн санг ашиглах, удирдах журам”-ын шинэчилсэн төслийг боловсруулсан. Мөн батлагдсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн системийн хөгжүүлэлтийг хийж дууссан.<br>Харин хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2023 оноос нийт хүүхдийн 91 хувьд олгохоор төсвийг хэлэлцэж байгаатай холбогдуулан Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 163 дугаар захирамжаар төрийн байгууллагын мэдээллийн санг ашиглан өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгож, хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох арга хэмжээг хэрэгжүүлэх саналыг боловсруулж танилцуулах ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хүрээнд ХНХ-ын сайдын 2022 оны А/189 дугаар тушаалаар төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, програм хангамж хөгжүүлэх болон Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлал, хэрэгжүүлэх журмын төслийг боловсруулах чиг үүрэг бүхий 2 дэд ажлын хэсгийг байгуулж, ҮСХ, ХНХЯ, СЯ, ЦХХХЯ, Монгол банк зэрэг холбогдох байгууллагууд хамтран ажилласан.<br>ХНХ-ын сайдын А/189 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгүүд хуралдаж, төрийн байгууллагууд хоорондоо шаардлагатай мэдээллээ хуулийн хүрээнд солилцох нөхцөлийн талаар шийдлийг боловсруулж, зохистой орчинг бүрдүүлж, ҮСХ-нд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж байна. Дээрх ажлын хэсгийн ажлын үр дүнд тулгуурлан өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох ажлыг эхлүүлнэ. | |
| 8 | | 2.3.7. Хүүхдийн тоо, наснаас хамааруулан хөнгөлөлт эдлүүлэх, хуримтлал бий болгох тогтолцоог бүрдүүлнэ. | 2020 - 2050 | | 2023 оны 01 сарын 01 өдрөөс хэрэгжинэ | Монгол Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийг 2021 оны 11 сард баталж, Ирээдүйн өв сангийн 2022 оны орлогоос Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд мөнгөн хуримтлал үүсгэх хууль эрх зүйн боломжийг бүрдүүлсэн. Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан “Хуримтлалтай Монгол хүүхэд” хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлж эхлэв. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын 2022 оны 36 дугаар тогтоолоор “Хүүхдийн мөнгөн хуримтлалыг Төрийн санд байршуулан хуримтлуулах, бүртгэх, олгох журам”-ыг баталсан. Уг журмын дагуу Монгол Улсын иргэн 18 нас хүрснээр Хүүхдийн мөнгөн хуримтлалыг мөнгөн хэлбэрээр авах бөгөөд энэ хүртэлх хугацаанд хуримтлалыг Төрийн сан дахь “Хүүхдийн мөнгөн хуримтлал”-ын дансанд хуримтлуулах ба дансны үлдэгдэлд хүү тооцож олгоно.<br>2022 оны 10 дугаар сарын байдлаар 29880 хүүхэд мөнгөн хуримтлал үүсгэсэн байна. Харин хүүхдийн мөнгөн хуримтлалаас 1,234.175 хүүхдэд 100.0 мянган төгрөгийг бэлэн мөнгө хэлбэрээр олгосон байна. | 100 |
| 9 | | 2.3.8. Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих, бодит | 2020 - 2050 | 803.9 сая | Нийт залуучуудын 45 хувийг залуучуудын хөгжлийн үйлчилгээнд хамруулна. | Аймаг, дүүрэг, зарим сумдад үйл ажиллагаа явуулж буй Залуучуудын хөгжлийн төв нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 450 мянга гаруй залуучууд буюу нийт залуучуудын 45 хувьд хөгжлийн үйлчилгээ үзүүлсэн. Хөгжлийн үйлчилгээний агуулгад Амьдрах ухааны 12 модуль сургалт багтдаг бөгөөд тус сургалтын хөтөлбөрт "Жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх нь", "Бэлгийн амьдрал: БЗДХ, ХДХВ-ээс сэргийлэх нь" зэрэг гэр бүлийн харилцааны талаарх ойлголт, мэдээлэл өгөх зарим модуль багтдаг. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ. | | | | | |
| 10 | | 2.3.9. Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажил, ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлнэ. (эцэг эхийн ажлын цагийн зохицуулалтыг оновчтой, сонголттой болгох, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт, зайнаас ажиллахыг дэмжих) | 2020 - 2050 | | 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-аар зохицуулсан. 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдсөн байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-т ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой тохиролцож болохоор заасан. Мөн 66 дугаар зүйлд Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, 67 дугаар зүйлд Гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ, 68 дугаар зүйлд Зайнаас ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ зэргийг тусгасан. Тус хуулийн 85 дугаар зүйлд Ажлын цагийг богиносгох нөхцөлийг заасан бөгөөд 85.1.2-т жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй ажилтны ажлын цагийг богиносгохоор эмнэлгийн магадалгаа гарсан, 88.5 Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол шөнийн цагаар ажиллуулахыг хориглоно. 91.4.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй бол илүү цагаар ажиллуулахыг хориглоно; 98.2.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй, эсхүл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулахыг хориглоно гэсэн заалт тусган батлуулж мөрдөж байна. Мөн 135 дугаар зүйлд Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлахыг хориглох, 136 дугаар зүйлд Хүүхэд хөхүүлэх, асрах нэмэлт завсарлага, олговор олгох,137 дугаар зүйлд Жирэмсний болон амаржсаны амралт, эцгийн чөлөө, 138 дугаар зүйлд Нярай хүүхэд үрчлэн авсан ажилтанд чөлөө олгох, 139 дүгээр зүйлд Хүүхэд асрах чөлөө олгох, 141.1.Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтныг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулахыг хориглоно зэрэг заалтыг тусган батлуулан, мөрдүүлж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-т ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой тохиролцож болохоор заасан. | 100 |
| 11 | | 2.3.10. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Оюутны хөдөлмөрийн бирж” байгуулж хөгжүүлнэ. | 2020 - 2050 | 1,030.0 мянган төгрөг | Цагийн ажил хийх хүсэлтэй оюутан залуучуудыг 85-аас доошгүй хувийг цагийн | Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дэргэдэх Цагийн хөдөлмөрийн биржид 2022 оны байдлаар 1739 оюутан залуучууд хандаж цагийн ажил хийхээр бүртгүүлж зөвлөгөө мэдээлэл авсанаас 95.5 хувь буюу 1661 оюутан цагийн ажлын байранд зуучлагдан ажилласан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 10,000 иргэнийг хамруулж, 70,0 сая төгрөгийн зарцуулахаар төсөвлөснөөс 2022 оны 05 дугаар сарын байдлаар нийслэлд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажлын байранд зуучилсан байна. | цагийн ажилд зуучлах арга хэмжээнд /НХЭГ, СХД/ 959 иргэн хамрагдаж, 891 иргэн ажилд зуучлагдан, 1,030.0 мянган төгрөг зарцуулсан байна.<br>Нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц цагийн ажлын байрыг гаргаж оюутан, залуучуудын цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нийгмийн хариуцлагыг хүлээсэн 100-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагуудын жагсаалтыг шинэчилж, их, дээд сургууль, коллежийн дэргэдэх Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвүүдийн 60-аас доошгүй хувьд хүргүүлж хамтран ажиллав. | |
| 12 | | 2.3.11. Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа монгол иргэдийн мэдээллийн сан бүрдүүлж, тэднийг иргэний эрхээ эдлэх боломж, нөхцөлийг техник, технологийн ололтод тулгуурлан бүрдүүлж, эх орондоо чиглэсэн бизнесийн болон сайн дурын үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээ хийх, эх нутагтаа эргэн ирж ажиллаж, хөдөлмөрлөхөд дэмжлэг болохуйц эрх зүйн орчныг бүрдүүлж, цахим хөдөлмөрийн биржь, мэдээллийн систем ажиллуулна. | 2020 - 2050 | - | - | Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын 20 дугаар зүйлд "Монгол ажилтныг эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх" тухай тусгасан болно. Эх орондоо буцаж ирсэн монгол ажилтанд ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, хөдөлмөр эрхлэхэд хууль тогтоомжид заасны дагуу дэмжих, төсөл, хөтөлбөрт хамруулах дэмжлэг үзүүлнэ. Энэхүү үйл ажиллагааны санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, холбогдох Засгийн газрын тусгай сангийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр тусгасан болно. Мөн Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ийг шинэчлэн баталсан. Журмын 2.2-т зээл хүсэгч нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан иргэн, аж ахуйн нэгж байх бөгөөд нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн нь байгуулж буй нөхөрлөл, хоршоогоо Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэхээр мэдүүлсэн иргэдийн эрх бүхий төлөөлөгч, гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн нь гадаад улсад суралцахаас бусад зорилгоор ажиллаж, амьдарч байгаад эх орондоо буцаж ирээд 48 хүртэл сар болж байгаа иргэн байх бөгөөд 25 хүртэлх сая төгрөг байна.<br>Гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол Улсын иргэд эх орондоо чиглэсэн бизнесийн болон сайн дурын үйл ажиллагаа, судалгаа, шинжилгээ хийх, эх нутагтаа эргэн ирж ажиллаж, хөдөлмөрлөхөд дэмжлэг болохуйц Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем "Ejob" платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажилласан.<br>"Ejob" платформд гадаадад сурч, хөдөлмөрлөж байгаа Монгол иргэдэд зориулсан сан бүхий хэсэг, хөдөлмөр эрхлэх ур чадварын үнэлгээ (профайлинг) модуль хэсгийг шинэчлэн хөгжүүлж, эх орондоо эргэн ирж ажиллах нөхцөл боломцоог ханган ажилд зуучлах, ажил хайх үйлчилгээг онлайн хэлбэрээр авч болохоор программ хангамжийн хөгжүүлэлт хийгдээд байна.<br>"Ejob" платформыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад орууллаа. | 100 |
| 13 | | 2.3.12. Залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, мэргэжлийн, судалгааны болон хувийн хэвшлийн | 2020 - 2050 | 803.9 сая | Гэр бүлийн боловсрол, олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг олон талын оролцоотой | Залуучуудын хөгжлийн төв 21 аймаг, 9 дүүрэг, 5 сум (Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Номгон, Булган)-д ажиллаж, амьдрах ухааны сургалт, сонирхлын клуб, зөвлөлийг ажиллуулах, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн зөвлөгөө үйлчилгээ, тусламж, гэр бүлийн зөвлөгөө, хөдөлмөр эрхлэлтийн сургалт, зөвлөгөө, зуучлалын үйлчилгээнд жилд дунджаар нийт залуучуудын 40 хувийг хамруулдаг бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагуудтай хамтран ажиллана. | | | хөгжүүлж, нийт залуучуудын 45 хувийг, хамруулна. | 450 мянга гаруй залуучууд буюу нийт залуучуудын 45 хувьд хөгжлийн үйлчилгээг хүргэсэн. Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй "Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь" төслийн хүрээнд "Тэгш боломжийн төлөөх залуучуудын манлайлал" жендэрийн сургагч багшийн сургалтын гарын авлагыг боловсруулан хэвлүүлж, аймаг, дүүрэг, зарим сумдын Залуучуудын хөгжлийн төвийн 80 гаруй мэргэжилтнийг жендэрийн сургагч багшаар бэлтгэсэн. Сургагч багш нар орон нутагтаа залуучууд, олон нийтийг жендэрийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтад дараах байдлаар хамруулна. Үүнд: Залуучуудын хөгжлийн төв тус бүр залуучуудын 8 зорилтот бүлэг тус бүрт 3-аас доошгүй буюу нийт 24 удаагийн сургалтыг зохион байгуулж 480 залуучууд буюу зорилтот бүлэг тус бүрээс 60-аас доошгүй залуучуудыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. 8 зорилтот бүлэгт дараах залуучууд хамаарна: 15-19 насны охид хөвгүүд; гэр бүл салсан; гэр бүл болох оюутан, цэрэг; хорих ангид хүмүүжигч; хорих ангиас суллагдсан 15-34 насныхан; малчид; сайн дурын ажил хийж буй залуучууд; цэргийн ангийн албан хаагчид зэрэг болно | |
| 14 | 2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно. | 2.6.2. Байнгын ажил олгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | 25.7 тэрбум | 2281 хүн | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, байнгын болон түр ажлын байраар хангах зорилго бүхий хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг баталсан. Үүнд "Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр", "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр" "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр", "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-үүдэд нэмэлт, өөрчлөлтийг оруулж баталсан бол "Ногоон ажлын байр хөтөлбөр", "Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-үүдийг шинээр 2022-2023 онд хэрэгжүүлэх юм.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/44 дугаар тушаалаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсвийн хуваарийг батлаж, дээрх хөтөлбөрүүдэд 59.7 тэрбум төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн нь өмнөх оноос 2.7 дахин нэмэгдсэн байна. 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдээр дамжуулан Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Дээрх санхүүжилтийн 25.7 тэрбум төгрөг нь иргэдийн байнгын ажил орлоготой болгох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж барьцаагүй, хүүгүй, зорилтот бүлгээс хамааран 100%, 50% эргэн төлөгдөх нөхцөлтэй болон эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдэд ил тод, нээлттэй зарлаж, иргэдийн хүсэлтийг хүлээн авч, сонгон шалгаруулж, санхүүжилт олгож эхэлсэн.<br>2022 оны 12 дугаар сарын байдлаар хөтөлбөр тус бүр дээр санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг дараах байдлаар зарцуулсан байна. Үүнд:<br>• Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт 5980 иргэн хамрагдаж, 17.8 тэрбум төгрөгийг,<br>• Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 733 иргэн хамрагдаж, 395.5 сая төгрөгийг,<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 960 иргэн хамрагдаж, 6.0 тэрбум төгрөгийг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | | | | | | • Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ххөтөлбөрт 990 ахмад, 4.3 тэрбум төгрөгийг,<br>• Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 22 иргэн, 180.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.<br>Нийт 8685 иргэн хамрагдаж, 28.7 тэрбум төгрөгийг олгосон байна. | |
| 15 | | 2.6.3. Ажлын байр олноор бий болгож байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулна. | 2020 - 2050 | 200.0 сая<br><br>121.0 сая | 50 ААНБ<br><br>110 ААНБ | Ажил олоход хүндрэлтэй иргэн, ялангуяа нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны бөгөөд хөдөлмөрийн чадвартай иргэнийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байраар хангах зорилгоор “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 1 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан. Тус тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.1 дэх заалтад Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох, дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 4.4 дэх заалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэхээр тус тус заасан.<br>Уг арга хэмжээг 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж байна. 2022 оны 12 дугаар сарын байдлаар ажил олгогчийг дэмжих арга хэмжээний урамшуулалд 25 ажил олгогч, 35 иргэн хамрагдаж, 38 ажлын байр бий болж, 160.0 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчид 108.5 сая төгрөгний дэмжлэгийг тус тус олгосон байна.<br>Мөн Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн 4.3 дахь заалт “Нийгмийн хариуцлагатай хувийн хэвшил, төрийн байгууллага, нөхөрлөл хоршоог шалгаруулна гэж заасны дагуу оны төгсгөлд сонгон шалгаруулдаг болно. Тус сонгон шалгаруулалтыг эхлүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.<br>/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 15.1.2 заасснаар ажил олоход хүндрэлтэй иргэн нь үндсэн ажилтнаар 1 жилээс доошгүй хугацаанд ажиллахаар заасан/. | 50 |
| 16 | | 2.6.4. Ажлын байрны мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргаж, хөдөлмөр эрхлэлтийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулна. | 2020 - 2050 | 70.0 сая | Динамик загварын хөгжүүлэлт | Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг удирдах болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, зохицуулалтын шийдвэр гаргахад шинжлэх ухааны үндэслэл, тооцоо, судалгаатай байх боломжийг бүрдүүлэхэд анхаарч, ОУШХБ-ын дэмжлэгтэйгээр системийн динамик загварыг боловсруулж, туршилтаар ажиллуулж эхлээд байна.<br>“Хөдөлмөр эрхлэлтийн системийн динамик загвар”-ыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын шийдвэр гаргахад ашиглахаас гадна үндэсний хэмжээний хөгжлийн бодлого, төлөвлөлт, салбар дундын болон бүс нутгийн хэмжээнд шийдвэр гаргахад ашиглах бүрэн боломжтойгоороо ач холбогдолтой юм.<br>Хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлыг туршин, халамжаас хөдөлмөрт шилжих бодлогын хүрээнд Нийгмийн даатгалын болон Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчлэлүүдийн тооцооллыг системийн динамик загварчлалын аргаар хийлээ.<br>Тухайлбал Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх, Хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгоход нөлөөлөх эерэг болон сөрөг нөлөөлөл, ирээдүйн төсөөллийг тодорхойлох, оновчтой хувилбаруудыг турших ажлуудыг хийж гүйцэтгэлээ.<br>Цаашид энэхүү динамик загварыг Монгол Улсын эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн болон ирээдүйн төлөвийг тодорхойлон бодлого, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэр гаргахад ашиглахаас гадна их дээд сургуулийн багш, оюутан, эрдэм шинжилгээний байгууллагын судлаач, иргэдэд нээлттэй байдлаар ашиглах боломжийг бий болгохоор зорин ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг хөгжүүлэх, үйл ажиллагааг цаашид хариуцан ажиллах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтийн баг хамт олонд уг загвараар тооцсон зарим туршилтын үр дүнг танилцуулан, загварыг хүлээлгэн өгөх арга хэмжээг 2022 оны 04 дүгээр сард зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ судалгааны институтын загварыг хөгжүүлсэн зөвлөх багтай хамтран ажиллан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик тоон мэдээлэл болон загварын тооцооллын нарийвчлалыг сайжруулахаар ажиллаж байна. Загвар хөгжүүлэлтийн хүрээнд динамик загвараар симуляци хийхэд нэн шаардлагатай байгаа дараах мэдээллүүдийг тулгах, нарийвчлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>**Нийгмийн хамгааллын тооцоолол, хөгжүүлэлт:** Өрхийн орлогын тоон мэдээлэл;<br>**Нийгмийн даатгалын** тооцоолол **хөгжүүлэлт:** Тэтгэвэр, даатгуулагч, цалинтай холбоотой тоон мэдээллүүд;<br>***Хөдөлмөр эрхлэлтийн тооцоолол хөгжүүлэлт***: Ажилчдын тоон мэдээллийг сайжруулах зэрэг ажлуудыг хийлээ.<br>Хөдөлмөр эрхлэлтийн динамик загварыг хөгжүүлэх жишиг ажлын даалгаврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/103 дугаар тушаалаар батлан Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.<br>Мөн Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ хариуцсан мэргэжилтнүүд ашигласнаар ажил хайгч, ажил олгогч, ажлын байрны мэдээллийг аймаг, сум, дүүргээр гаргаж, дотоод шилжилт хөдөлгөөнийг хянах боломж бүрдэж байна. | |
| 17 | | 2.6.5. Дотоодын нийт бүтээгдэхүүнд цалин болон түүнтэй тэнцэх орлогын эзлэх хувиар шалгуур үзүүлэлт болгон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрэх үр дүнг тогтооно. | 2020 - 2050 | 155.3 тэрбум төгрөг | Төрийн албан хаагчдын сарын дундаж цалин 1296.1 мян.төг | Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг тогтоосон. Үр дүнд нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлс 8.5 хувиар нэмэгдсэн. Мөн Засгийн газрын 2022 оны 193 дугаар тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын ТЗ-6 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн туслах болон ТЗ-5 зэрэглэлд хамаарах анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг, төрийн захиргааны албан тушаалын АА-9 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүгчийн туслах болон АА-10 зэрэглэлд хамаарах Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоосон.<br>Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсөвт төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх замаар цалин хөлсийг ажилласан жил, бүтээмж, хүрсэн үр дүнтэй уялдуулан тогтоодог болох, төрийн албан хаагчдын цалин хөлсийг тодорхой хувь хэмжээгээр нэмэгдүүлэх дараах арга хэмжээ тусгагдсан. Үүнд:<br>• Төрийн албаны цалингийн олон шатлал, зэрэглэлийг цэгцлэн үндсэн цалинг шатлалгүй болгож, төрийн захиргааны 15 зэрэглэлийг 10 болгоно. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлнэ.<br>• Орон нутагт ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, төвлөрлийг сааруулах хүрээнд орон нутгийн нэмэгдэл олгоно. Ингэхдээ улсын төсвөөс 20 хувийн нэмэгдлийг олгох ба энэ хэмжээг 100 хүртэл хувьд хүргэх эрхийг орон нутагт нь олгоно.<br>• Нийт төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг дээшлүүлэх хүрээнд тэдний ажилласан жил бүрийг үнэлж нэмэгдэл олгодог болно.<br>• Төрийн захиргааны албан хаагчдын хариуцлага, ажлын үр дүн, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн удирдах албан тушаалтнуудыг ажлын үр дүнгээр нь, төрийн гүйцэтгэх албан тушаалтнуудыг гүйцэтгэлээр нь үнэлдэг болно.<br>Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд 2023 оны улсын төсвийн төсөлд нийт 266.2 тэрбум төгрөг тусгагдаад байна. | |
| 18 | | 2.6.6. Гэр бүлийн анхдагч хэрэгцээг цалин, орлогынхоо 50 хувиар хангахаар тооцож цалингийн тогтолцоог шинэчилнэ. | 2020 - 2050 | - | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 550.0 мянган төгрөг | Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хороо 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 3273 төгрөг 80 мөнгө буюу сард 550,000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосон. | 100 |
| 19 | | 2.6.7. Иргэдийн цалин, урамшууллыг тогтмол нэмэгдүүлэхэд компанийн нийгмийн хариуцлагын хөтөлбөрийг дэмжин урамшуулна. | 2020 - 2050 | 140.0 тэрбум төгрөг | Ажиллагчдын сарын дундаж цалин 1544.4 мян.төг | Цалин хөлс нь ажилтан болон ажил олгогчийн хоорондын сонирхлын тэнцвэрийг хангах, ажилтныг идэвхжүүлэх, сэдэлжүүлэх замаар ажлын байранд нь тогтвор суурьшилтай ажиллуулах гол механизм юм. ХНХЯ-наас ”Цалин хөлс тогтоох аргачлал”, “Ижил үнэлэмжтэй ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны цалин хөлсний хэмжээ адил байх зарчмыг хэрэгжүүлэх аргачлал”-ыг тус боловсруулан Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 2 болон 6 дугаар тогтоолоор тус тус батлууллаа. Дээрх аргачлал нь аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд цалин хөлс тогтоох, нэмэгдүүлэхэд үндэслэх арга зүйн гол хэрэгсэл юм. | 30 |
| 20 | | 2.6.8. Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй, ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох мэргэжлийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх бодлого, “Хиймэл оюун ухаан ба ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | 75 сая Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа | 75 сая | Тус яамны харьяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-г жил бүр хийж, нийтэд мэдээлж байгаа бөгөөд энэхүү судалгаа нь хөдөлмөрийн зах зээлийн богино хугацаа буюу дараа жилийн ажиллах хүчний хэрэгцээ, мөн өнгөрсөн жилийн хугацаан дахь ажиллах хүчний хомсдолыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжил, байршлаар тодорхойлж, санал зөвлөмж боловсруулдаг.<br>Улсын хэмжээнд 2022 онд 78.0 мянган ажлын байр бий болох ба тэдгээрийн 72.9% хувь нь оны эхний хагаст, үлдсэн 27.1 хувь нь сүүлийн хагаст бий болох төлөвтэй байна.<br>Ажиллах хүчийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал салбар бүр харилцан адилгүй байна. Өмнөх оны мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их өссөн салбаруудыг авч үзвэл, боловсруулах үйлдвэрлэл 24.4 мянгаар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 14.3 мянгаар, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 12.9 мянгаар, боловсрол 9.7 мянгаар, урлаг, үзвэр, тоглоом, наадмын салбар 7.9 мянгаар тус бүр нэмэгджээ. Харин өмнөх оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мөн үеэс ажиллагчдын тоо нь хамгийн их буурсан салбарууд бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ 11.3 мянгаар, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 10.1 мянгаар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 5.1 мянгаар тус бүр буурсан байна.<br>Ажиллах хүчний эрэлт бүс нутгийн хувьд нэлээд ялгаатай байдаг бөгөөд ихэнх хувь нь Улаанбаатар хотод харьяалагдаж, хангай болон төвийн бүсэд нийт ажиллах хүчний эрэлтийн 20.7 хувь ноогдож байна.<br>Ажил олгогчид ажил хайгчийн мэргэжлийн нарийн ур чадвар гэхээс илүүтэй хувь хүний зөөлөн ур чадварыг хамгийн чухал үзүүлэлт гэж үздэг хандлага хэвээр төдийгүй бие даан ажиллах чадвар, найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай байдал, харилцааны ур чадвар, цаг ашиглах чадварыг хамгийн ихээр чухалчилж үзжээ. Эдгээр зан чанарын зөв төлөвшил бүхий ажил горилогчид мэргэжлийн ур чадварыг дадлага болон төрөл бүрийн сургалт, арга хэмжээгээр эзэмшүүлэх боломжтой гэж үзсэн хэвээр байна. Харин мэргэжлийн ур чадварын хувьд төдийлөн өндөр шаардлага тавихгүй ч, ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, ажлын ёс зүйтэй байх, шинэ санаа гаргах чадварыг илүүд үзэж, боловсролын түвшний тухайд тодорхой хэмжээний боловсрол эзэмшсэн байх шаардлагыг түлхүү дурдсан байна. Энэ хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийг баталсан. Хөтөлбөрийн 4.1, 4.2 дахь заалтад хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэн болон ажил олоход хүндрэлтэй иргэдэд хувь хүний харилцаа, хандлага, хөдөлмөрийн аюулгүй байдал зэрэг ажлын байран дахь харилцааны ур чадвар, сэтгэл зүйн сургалт явуулж, ажлын байранд зуучлахаар тус тус заасан.<br>2022 оны 12 дугаар сарын байдлаар Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалтад 5895 иргэн хамрагдаж 159.1 сая төгрөг зарцуулж 535 иргэн ажлын байраар хангагдсан байна.<br>Танхимын сургалтад 1843 иргэн хамрагдаж 301.9 сая төгрөг зарцуулж, 106 иргэн ажлын байраар хангагдсан байна. | |
| 21 | | 2.6.10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн салбар дундын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | - | - | Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хүнд үйлдвэрүүдийн ажиллах боловсон хүчнийг бэлтгэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх, одоо ажиллаж байгаа ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг хангуулах, тогтолцоог бүрдүүлэх, санал, зөвлөмж боловсруулах, энэ талаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох үүрэг бүхий ажлын хэсгийг холбогдох яам, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд, эрдэмтэн багш, судлаачдын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд салбар бүрийн шаардлагатай статистик тоон мэдээлэл, судалгааг нэгтгэн дүн шинжилгээ хийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхээр хамтран ажилласан.<br>Мөн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн хүрээнд боловсруулж байгаа Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдэд бусад салбаруудын бодлогын хүрээнд шийдвэрлэх хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг тусгаж байна. Түүнчлэн “Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн Зорилт 5-д Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх асуудлыг тусгасан. УИХ-аар Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг батласны дараа салбар | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүр Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг батлах бөгөөд энэ үед холбогдох яамдтай хамтран ажиллана. | |
| 22 | | 2.6.11. Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим болон зайн ажлын байрыг нэмэгдүүлэн тогтолцоог нь дэмжиж хөгжүүлнэ. | 2020 - 2050 | | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найрулгыг 2022.01.01-с хэрэгжиж байна. | УИХ-аас 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр батлагдсан Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ажилтныг гэрээсээ ажиллах, зайнаас ажиллах, бүтэн бус цагаар ажиллах, иргэд хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулах зэрэг зохицуулалт шинээр туссан. Ингэснээр ажилтан, ажил олгогч харилцан тохиролцон хөдөлмөр эрхлэлтийн хэв шинжид тохирсон уян хатан зохицуулалтыг хэрэглэх боломж бүрдсэн. | 100 |
| 23 | | 2.6.13. Хүн амын бүлэг бүрийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | 59.7 тэрбум ХЭДС | 40000 хүн | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 01 тогтоолоор зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, байнгын болон түр ажлын байраар хангах зорилго бүхий 7 хөтөлбөр, 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан. Үүнд “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”, “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг 2022-2023 онд хэрэгжүүлж байна.<br>2022 оны 12 дугаар сарын байдлаар 7 хөтөлбөр 28 арга хэмжээнд нийт 55000 иргэн хамрагдаж үүнд 39.0 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. | 100 |
| 24 | | 2.6.14. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2020 - 2050 | | 6 барилгын тооцоолол, зураг төслийг боловсруулж, батлуулсан байна. | Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай 2018 оны 4 сарын 4-ний өдөр байгуулсан гэрээний хүрээнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний оролцоог хангаж, үйлчилгээг сайжруулах” төслийг хэрэгжүүлж, Архангай, Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл аймагт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийг байгуулахаар болсон. Энэ жил Ховд, Дорнод, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл аймагт барилга баригдаж ашиглалтад ороод байна.<br>Архангай аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга гүйцэтгэл 45%-тай байна.<br>-Дээрх аймгуудад “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийг “Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын тухайн орон нутаг дахь салбар хэлбэрээр байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад даалгасан Засгийн газрын 2021 оны 164 дүгээр тогтоол батлагдсан.<br>Энэ хүрээнд тус төвийн бүтэц, зохион байгуулалт, ажиллах дүрмийг ХНХ-ын сайдын 2022 оны 8 дугаар сарын 17-ны А/159 дүгээр тушаалаар баталсан. | 100 |
| 25 | | 2.6.15. Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно. | 2020 - 2050 | - | Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талаар Нийгмийн даатгалын багц хуулийн төсөлд тусгасан байна. | Нийгмийн даатгалынн багц хуулийн төслийг боловсруулан 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлээд байна. Хуулийн төсөлд Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох талаар тусгасан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | | 2.6.16. Хүн амын бүлгүүд, тухайлбал эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно. | 2020 - 2050 | - | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022.01.01-с хэрэгжиж байна. | Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-т ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой тохиролцож болохоор заасан. Мөн 66 дугаар зүйлд Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ, 67 дугаар зүйлд Гэрээсээ ажиллах ажилтны хөдөлмөрийн гэрээ, 68 дугаар зүйлд Зайнаас ажиллах ажилтны хөдө<br>144.7.Хөгжлийн бэрхшээлтэй хүн тэтгэвэр, тэтгэмж авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй;<br>144.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асардаг ажилтан хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч түүнд гэрээсээ, зайнаас, бүтэн бус цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжит арга хэмжээг авна.лмөрийн гэрээ зэргийг тусгасан.<br>145.2.Ажилтан өндөр насны тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.<br>145.3.Ажил олгогч ахмад настны хүсэлтээр ажлын цагийг богиносгож, бүтэн бус цагаар ажиллуулж, эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна гэсэн заалт тусган батлуулан, мөрдөж ажиллаж байна.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 43.3-т ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлнэ гэж заасан. Түүнчлэн хуулийн 140 дүгээр зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй ажилтан ажил үүргээ гэрээсээ, эсхүл зайнаас гүйцэтгэхээр ажил олгогчтой тохиролцож болохоор заасан. | 100 |
| 27 | | 2.6.17. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаадын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүний эрх, нийгмийн хамгааллын баталгаа бүхий орчин, нөхцөлд шийдвэрлэж, хүн амын аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна. | 2020 - 2050 | - | - | УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахад хязгаарлалт тогтоохгүй байх зохицуулалтыг бий болгохоор Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан "Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам"-д нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг 2022 оны 02 дугаар сарын 16, 02 дугаар сарын 23-ны өдрүүдийн Засгийн газрын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэн, Засгийн газрын 2022 оны 80 дугаар тогтоолоор батлуулав.<br>Журамд аж, ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөхөөр туссан. 2022 оны 12 дугаар сарын байдлаар "Ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны 11 удаагийн тушаалаар хүсэлт ирүүлсэн нийт 292 аж ахуйн нэгж, байгууллагын 3829 гадаад ажиллах хүч, мэргэжилтний ажлын байрны төлбөрийг 50 хувиар | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөнгөлөөд байна.<br>Цаашид төрийн захиргааны төв байгууллагуудаас ирсэн саналд үндэслэн ажлын байрны төлбөрийг хөнгөлөх шийдвэрийг тухай бүр гаргана.<br>Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх зохицуулалтыг бий болгохоор "Гадаадаас 2022 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2021 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 339 дүгээр тогтоолыг хүчингүй болгох, тоо хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй байх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн ээлжит хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газраар 2022 оны 231 дүгээр тогтоолоор батлуулав. Улмаар хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд аливаа хязгаарлалт тавихгүйгээр Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгож байна.<br>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу “Монгол Улсад 2023 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 359 дугаар тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан.<br>Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 21.3.3 -т заасан нарийн мэргэшлийн ажлын байрны жагсаалтыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хоёр жил тутамд 10 дугаар сарын 01-ний дотор Засгийн газар батална” гэж заасны дагуу тогтоолын төслийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр, эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар боловсруулан 2022 оны 10 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төслийг хүргүүлсэн. Гадаадаас авах нарийн мэргэшлийн жагсаалт нь салбар дундын олон талын оролцоотой асуудал тул чиг үүргийн яамдуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж нарийн мэргэшлийн жагсаалтыг дахин боловсруулах шаардлагатай гэж үзсэн тул 2023 оны 1 дүгээр улиралд Засгийн газрын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна. | |
| 28 | 2.7. Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ. | 2.7.1. Хүн бүр удмаа мэдэж, угийн бичгээ хөтлөх үндэсний уламжлалыг сэргээн хөгжүүлж, угийн бичиг хөтлөх, цус ойртолтыг багасгах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | - | “Угийн бичиг"-ийг айл өрх бүрд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөтлүүлэн хэвшүүлэх ажлыг зохион байгуулж, нийт өрх, гэр бүлийн 30 хувьд хүрч ажиллана. | Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байх эрх зүйн зохицуулалтыг тусгагдаад байна.<br><br>Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, хүн амын өсөлтийг дэмжих талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их хурлын 2022 оны 01 дугаар тогтоол батлагдсан. Уг тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2022.10.27-ны өдрийн 175 дугаар захирамж гарч, монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах, угийн бичиг хөтлөх журмыг сэргээн хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, “Угийн бичиг хөтлөх, цус ойртолтоос сэргийлэх арга хэмжээ”-ний болон “Угийн бичиг хөтлөх журам”-ын төсөл боловсруулах Ажлын хэсгийг Соёлын сайдаар ахлуулан байгуулаад байна. | 30 |
| **Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | | | | |
| 29 | 3.1. Амьдралын баталгааг хангах | 3.1.1. Албан бус салбарт хөдөлмөр | 2020 - 2050 | Уг хуулийн үйлчлэлд 2021 | Малчин, хувиараа | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ. | эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. | | оны жилийн эцсийн байдлаар 34.4 мянган даатгуулагч хамрагдаж, 76.3 тэрбум төгрөгийн шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд нөхөн төлсөн байна. Үүнээс нийт 15.8 мянган иргэн тэтгэврээ тогтоолгосон бөгөөд тэтгэврийн зардалд 67.5 тэрбум төгрөг одоогийн байдлаар зарцуулсан байна. | хөдөлмөр эрхлэгч нь нэг сард 42 000 төгрөг (420 000 төг*10%), нэг жилд 504 000 төгрөг (42 000 төг*12 сар)-өөр тооцож нөхөн төлсөн байна. | боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br>Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн болович Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн 22 дугаар зүйлд “Малчин нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг өөрөө, 50 хувийг улсын төсвөөс төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна” гэж тусгасан болно. | |
| 30 | | 3.1.2. Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | 2020 - 2050 | Гадаадын зээл, тусламж 238.5 мян. $ | Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулсан байна. | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br><br>Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн болович Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл нь одоо мөрдөгдөж буй эв санааны нэгдлээс хуримтлалын тогтолцоонд шилжих, нийгмийн даатгалаас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр нь даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацаа, төлсөн шимтгэлийн хэмжээтэй уялдаатай байх, мөн санхүүгийн тогтвортой, | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бие даасан, найдвартай байдлыг хангасан байх зэрэг зарчимд үндэслэн боловсруулж, шинэчлэлийн асуудлыг тусгав. | |
| 31 | | 3.1.3. Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно. | 2020 - 2050 | | Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна. | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс "Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ" гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br><br>Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Үзэл баримтлалын төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцооны харилцааг хуулийн төслийн 2 дугаар бүлгээр зохицуулахаар тусгасан болно. | 70 |
| 32 | | 3.1.4. Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ. | 2020 - 2050 | | Нийгмийн даатгалын тухай багц хуультай хамт 2022 оны намрын чуулганд өргөн барина. | Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан "Алсын хараа-2050", "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/197 дугаар тушаалаар байгуулсан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдөр хамтран батлуулав.<br>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэх ажлын хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг тус газар эцэслэн боловсруулав. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл нь 11 бүлэг, 60 зүйлтэй. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээ, эдгээр хуулиудын төсөлтэй хамт өргөн мэдүүлэх хуулиудын төсөл болон хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нэмэгдэж гарах зардлын тооцоог тус тус хийж гүйцэтгэсэн. Энэхүү хуулийн төслийг дагалдуулан 13 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулав.<br>Мөн "Хувийн нэмэлт тэтгэврийн тухай" хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ хийж, тайлан боловсруулав.<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд санал авах зорилгоор хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, холбогдох судалгааны хамт бүх яамдад 2021 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 1/1745 тоот албан бичгээр, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон холбогдох төрийн бус байгууллагуудад 2021 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | | | | | | оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1755 тоот албан бичгээр, Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкинд 2021 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 1/1755 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ээлжит уулзалт, хэлэлцүүлгийг 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулав. Уг ажлын хэсэгт Монголын хөрөнгийн бирж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Ард лайф ХХК, Тэтгэврийн ууган сан, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл, мөн актуарч, холбогдох судлаач нарын төлөөлөл оролцсон.<br>Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэв.<br>Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл болон Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 2022 оны намрын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг хүргүүлсэн. | |
| 33 | | 3.1.5. Нийгмийн даатгалын мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна. Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ. | 2020 - 2050 | - | Нийгмийн даатгалын цахимжуулсан үйлчилгээний тоо нэмэгдэж ажил олгогч, даатгуулагч иргэдэд үзүүлэх үйлчилгээ чирэгдэлгүй, хялбар, шуурхай, хүнд сурталгүй болсон байна. | Нийгмийн даатгалын 34 төрлийн үйлчилгээний 18 үйлчилгээ нь цахимжсан.<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон бусад агентлаг хамтран 2022 оны 01 дүгээр сараас эхлэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимжуулж, улмаар хөдөлмөрийн чадвар алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар олгож эхэлсэн.<br>Хөдөлмөрийн чадвар алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас, ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийг 2022 оны 05 дугаар сараас E-Mongolia цахим системд холбов.<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглаж байгаа програм хангамжуудыг вэб технологид суурилсан нэгдсэн нэг цогц систем болгон нэвтрүүлэх ажлыг Азийн хөгжлийн банкны төслийн санхүүгийн дэмжлэгээр ITZone компани гүйцэтгэж байна. | 90 |
| 34 | | 3.1.6. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно. | 2020 - 2050 | - | 2022 онд Холбогдох хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br>Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төслийн 13 дугаар зүйлээр Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг нарийвчлан зохицуулсан. | |
| 35 | | 3.1.7. Тэтгэврийн нөөц санг ашигт малтмалын орд газрын орлогын өгөөж болон ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрээс бүрдүүлнэ. | 2020 - 2050 | - | 2022 онд Холбогдох хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчилж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулж 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлэв. УИХ дахь олонхийн бүлгээс “Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттай шилжүүлнэ” гэсэн бодлоготой уялдуулан нийгмийн даатгалын багц хуулийг дахин боловсруулж өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгсөн.<br><br>Энэхүү чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслүүдийг буцаан татаж, дахин боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 1/1385 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг буцаан авч, үзэл баримтлал, тандан судалгааг дахин боловсруулан батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 01/3041 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд даатгуулагчийн төлсөн шимтгэлийн тодорхой хувь болон нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар, уг нөөц санг бүрдүүлэх эх үүсвэртэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг тусгаад байна. | 70 |
| 36 | | 3.1.8. Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно. | 2020 - 2050 | | 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгох зохицуулалт хуулийн төсөлд тусгагдсан байна. | Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгох эрх зүйн зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд тусгаад байна. | 100 |
| 37 | | 3.1.9. Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ. | 2020 - 2050 | | Нийгмийн даатгалын тухай ерөнхий хуулийн төсөлд тусгасан байна. | Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн хүрээнд хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих эрх зүйн зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлд тусгаад байна. | 100 |
| 38 | | 3.1.10. Нийгмийн халамжийн тусламж, | 2020 - 2050 | | Нийгмийн халамжийн | Нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийн нэр төрөл, хамрах хүрээг оновчтой болгох, давхардлыг арилгаж халамжийн туслалцаа хамгийн их шаардлагатай | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжлэг, үйлчилгээг зорилтот, эмзэг бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглүүлнэ. | | | тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна. | зорилтот бүлэгт тэтгэвэр, тэтгэмжийг чиглүүлэх үндсэн зарчмыг баримтлан Нийгмийн халамжийн багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулсан. Нөгөө талаар нийгмийн халамж болон хүн амын өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг ялгаж, салгах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.<br>Уг хуулийн төсөлд зорилтот бүлгийн иргэд, өрхүүдэд зөвхөн мөнгөн тусламж үзүүлдэг хэт нэг талыг барьсан бодлогоос татгалзаж, нийгмийн халамж шаардлагатай өрх, иргэдийг чадавхжуулах, тэдний хэрэгцээнд нийцсэн шинэ төрлийн үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан. Тухайлбал, Зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, бусад үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан.<br>Нийгмийн халамжийн шинэчилсэн найруулгын төсөлд холбогдох яамдаас саналыг авч нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 1/2831 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br>2022 оны эхний хагас жилд Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийн талаар иргэд, олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Монгол HD телевизтэй хамтран 2 нэвтрүүлэг, 1 ярилцлага бэлтгэн Монгол HD телевизээр 2022 оны 6-р сарын 5-25-ны өдрүүдэд эфирээр цацаж олны хүртээл болгов.<br>2022 оны 8 дугаар сард Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотой Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГХЭГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн ХЭГ/1996 дугаар албан бичгээр буцаан ирүүлсэн.<br>Үүнтэй холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг дахин батлуулж яамдаас санал авч, хэлэлцүүлэхээр ажиллаж байна. | |
| 39 | | 3.1.11. Нийгмийн халамж хүртэгсдийн мэдээллийн санг блокчейн технологид суурилан боловсронгуй болгож, нийгмийн хамгааллын үйл ажиллагааг сайжруулна. | 2020 - 2050 | Дэлхийн банкны 4500$ | Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлсэн аргачлал батлагдсан байна. | Төрд байгаа иргэний мэдээллийг тухайн иргэнээс шаардахгүйгээр төрөөс үзүүлж буй халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор “Нийгмийн халамжийн нэгдсэн систем”-ийг хөгжүүлж, 2020 онд нэвтрүүлэв.<br>2020 онд “Насны хишиг”, “Жирэмсэн эхийн тэтгэмж”, “0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж”, “Ихэр хүүхдийн тэтгэмж”, “Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж”, “Эхийн алдар” одонгийн мөнгөн тусламж гэсэн 6 үйлчилгээг, 2021 онд халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж зэрэг 26 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг нэмж нэвтрүүлэн олголтыг хийж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар Нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээнээс 49 үйлчилгээг буюу нийт үйлчилгээний 72 хувийг цахим хэлбэрт шилжүүллээ. Ингэснээр иргэд e-mongolia, ehalamj.mn цахим хуудас, ebarimt аппликэйшныг ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргаж, үйлчилгээг бүрэн авах боломжтой боллоо.<br><br>-Мөн 21 аймаг 330 сум, 9 дүүргийн 171 хороонд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг цахим эрхийн бичиг (банкны карт)-ээр үзүүлж байна. “Нийгмийн халамжийн нэгдсэн систем” нэвтэрснээр иргэн нийгмийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | | | | | | халамжид хамрагдах хүсэлтээ төрийн байгууллагад очилгүйгээр нийгмийн халамжийн цахим хуудас болох ehalamj.mn, төрийн үйлчилгээний цахим машин "ТҮЦ машин", ebarimt аппликейшныг ашиглан гаргах, олон байгууллагаар явж цаасаар бүрдүүлдэг баримт бичгийн тоо багасах, өргөдөл, хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, өөрийн нэр дээрх арилжааны банкин дахь харилцах дансаараа дамжуулан халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн мөнгөө авах зэрэг иргэнд ээлтэй олон давуу талууд бий болов. Нийгмийн халамжийн ажилтан цахим системээр дамжуулан иргэдийн хүсэлтийг хүлээн авдаг болсноор иргэн цаасан материал бүрдүүлж, архивлах зэрэгт зарцуулдаг хугацаа багасаж, халамж шаардлагатай иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, гэрээр нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийх зэрэг нийгмийн ажлын үйлчилгээнд илүү хугацаа зарцуулах боломж бүрдлээ. | |
| 40 | | 3.1.12. Зорилтот бүлгийн өрхийг хөгжүүлэх, хамгаалах, тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх орон нутгийн онцлогт нийцсэн шинэ төрлийн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ. | 2020 - 2050 | АХБ-ны төсөл 1,7 тэрбум | | Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зорилтот өрхийн гишүүдийн зан үйл, хандлагыг өөрчлөх зөвлөгөө, сэтгэл зүйн засалд хамруулах, бусад үйлчилгээнд холбон зуучлах, амьдрах ухаан, хөдөлмөрт бэлтгэх сургалтад хамруулах, бие даан амьдрах чадвар дадлыг хэвшүүлэх зэргээр тухайн өрхийг чадавхжуулах, амьжиргааг дэмжихэд чиглэсэн урт хугацааны үйлчилгээг хэрэгжүүлэхээр тусгасан.<br><br>Энэхүү үйлчилгээг хэрэгжүүлэх загвар, аргачлалыг тодорхойлох зорилгоор дэлхийн улс орнуудын эмзэг бүлгийн өрхийг бие даан амьдрах, тогтвортой амьжиргаанд хүргэх ижил төстэй загваруудыг судалсан. Үүний нэг нь бусад оронд амжилттай хэрэгжиж байгаа “төгсөлтийн аргачлал” хөтөлбөрийн загвар бөгөөд энэ нь ядуу өрхүүдийн авч байгаа нийгмийн халамжийн тэтгэмжид суурилан ядуурлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, ядуурлын олон асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг олон хэмжээст аргачлал юм.<br>Хуулийн шинэчлэл батлагдан хэрэгжихээс өмнө Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөрийг АХБ-ны “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2”-ын хүрээнд Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянзүрх дүүргийн хүнсний эрхийн бичигт хамрагдаж байгаа зорилтот 1,520 өрхийн 18-55 насны иргэдийг хамруулах юм.<br>Уг туршилтын хөтөлбөр 2023 он дуустал хэрэгжих ба энэ оны 7-8 дугаар сард өрхийн баталгаажуулах судалгааны бэлтгэл ажлыг хангуулж, 3 дүүргийн 40 хорооны хүнсний эрхийн бичигт хамрагддаг 4000 гаруй өрхүүдийн амьдрал, нөхцөл байдлын судалгаа хийсэн. Улмаар уг туршилтын хөтөлбөрийн үр дүнд тулгуурлан өрхийн амьжиргааг дэмжих халамжийн гол хөтөлбөр, арга хэмжээний суурийг бүрдүүлэхийн тулд туршилтын хөтөлбөрийн үр нөлөөг тооцож, үнэлэх зорилгоор санамсаргүй түүврийн судалгааны арга (Randomized Controlled Trial-RCT)-ыг ашиглан суурь судалгааг 2022 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 12 дугаар сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж, улмаар уг туршилтын хөтөлбөрт хамрагдах болон хяналтын өрхүүдийг сонгохоор ажиллаж байна. | 90 |
| 41 | | 3.1.13. Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ | 2020 - 2050 | | Төлөвлөгөөг батлан 2022 оны үйл ажиллагааны | Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний шинэ загварыг туршин нэвтрүүлэхээр аймаг, сум, нийслэлээс дараах Сонгинохайрхан дүүрэгт “Ачлалт хүүхдүүд” ТББ, Дархан-Уул аймагт “Ахмадын хөгжлийн төв”, Сэлэнгэ аймгийн Мандал суманд Нэгдсэн эмнэлгийг түшиглэн 3 байршлыг сонгон | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна. | | | хэрэгжилтийг ханган загвар төвийн үйл ажиллагааны чадавхи бэхжүүлэх 3-аас доошгүй сургалт зохион байгуулах | хэрэгжүүлж эхлээд байна. Дээрх 3 байршилд санхүү, хүний нөөц, үйлчилгээний чанар, стратегийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дэмжих стратегиудыг танилцуулж, хэлэлцүүлэг хийж, шинээр гарч буй шаардлагатай стратеги чиглэлийг хамтран тодорхойлох зорилго бүхий сургалтыг үе шаттай зохион байгуулсан. Эрүүл мэндийн яамтай хамтран 3 зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааны чиглэлтэй “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 27-ний өдрийн А/127, А/333 тоот хамтарсан тушаал батлав.<br>Тус төлөвлөгөөнд Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний шинэ загварыг 3 байршилд туршин нэвтрүүлэх ажил тусгагдсан.<br>Энэ хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулав.<br>• Дархан-Уул аймагт “Ахмадын хөгжлийн төв”, Сэлэнгэ аймгийн Мандал суманд Нэгдсэн эмнэлэгийн төлөөлөлд цахимаар, Сонгинохайрхайн дүүрэгт байрлах Ачлалт Хүүхдүүд төрийн бус байгууллагын “Идэвхитэй насжилтыг дэмжих төв”-ийн бизнес төлөвлөгөө боловсруулах сургалтыг ХНХЯ болон ЭМЯ-ны холбогдох мэргэжилтнүүд, дээрх байгууллагын ажилтнуудын төлөөлөлд 2022 оны 5 дугаар сарын 27-28-ний өдрүүдэд танхимаар зохион байгуулсан.<br>Сургалтаар бизнес загварын зургийг боловсруулах, үйл ажиллагааны эхлэх үеийн зардлыг хамруулсан орлого зарлагыг тооцох, ирэх 3-5 жилийн тогтвортой мөнгөн урсгал тооцох зэрэг агуулгыг оролцогчдод өгсөн.<br>• “Идэвхтэй насжилтийг дэмжих төв”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах сургалтыг 2022 оны 6 дугаар сарын 20-23-ний өдрүүдэд холбогдох байгууллагуудад зохион байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан.<br>• Кейс менежментийн баримжаа олгох сургалтыг 2022 оны 7 дугаар сарын 8-ны өдөр цахимаар зохион байгуулсан.<br>• Сургалтаар Монгол Улсад олон нийтэд түшиглэсэн тусламж үйлчилгээний тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай кейс тодорхойлох болон хэрэгцээний цогц үнэлгээний хэрэгсэлийг сонгох, боловсруулах, төрлийг тодорхойлон гаргаж байна.<br>• ХНХЯ, ЭМЯ, АХБ, олон улсын зөвлөх Вай Чонгтой хамтран холбогдох байгууллагуудын төлөөлөл оролцсон Кейс менежментийн сургалтыг 2022.12.12-16-ны өдрүүдэд зохион байгуулсан. | |
| 42 | | 3.1.14. Эхний ээлжид эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална. | 2020 - 2050 | 107,0 сая төгрөг | “Оролцоо” төсөлд хамрагдсан залуучуудын 30-с доошгүй хувь нь эмзэг бүлгийн өрхийн гишүүн байна. | -Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2022 онд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулав.<br>Эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлогын хүрээнд эхний ээлжинд 18-34 насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор уг төслийг хэрэгжүүлж байна. Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Батлан хамгаалахын сайд 2022 оны 03 сарын 22-ны өдөр батлан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Төслийг 2022 оны 06 сарын 09-ний өдрөөс эхлүүлэн нийт 12 ээлжээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, ээлжийн хуваарь батлуулав. Төсөлд хамрагдах залуучуудын бүртгэлийн үйл ажиллагааг 2022 оны 05 сарын 16-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд www.e-mongolia.mn цахим | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | системээр бүртгэн, сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа. Төслийн нэгдүгээр ээлж 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 238 оролцогчтойгоор Зэвсэгт хүчний 119 дүгээр анги дахь төслийн хотхонд үйл ажиллагаа эхэлсэн. Мөн төслийн хоёрдугаар ээлж 06 дугаар сарын 25-ны өдөр 308 оролцогчтойгоор эхэлж, нийт оролцогчдын профайлинг үнэлгээний нэгтгэлээс харахад ажилд шууд зуучлагдах боломжтой буюу хувираа хөдөлмөр эрхлэх боломжтой иргэн 77, Ажилд зуучлах буюу хувиараа хөдөлмөр эрхлэхэд богино хугацааны үйлчилгээ, дэмжих арга хэмжээ шаардлагатай иргэн 116, Ажилд зуучлах буюу хувиараа хөдөлмөр эрхлэхэд урт хугацааны үйлчилгээ, дэмжих арга хэмжээ шаардлагатай иргэн 40, Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд тулгамдсан асуудлыг нь шийдвэрлэх боломжгүй иргэн 6 орлцогч байна. Төсөлд оролцогчид өөрийгөө илэрхийлэх чадвар, өөртөө итгэх итгэл, хөдөлмөрийн сэдэл нэмэгдсэн байгаа нь профайлингийн ярилцлага хийх үед нийтлэг байдлаар ажиглагдсан нь төслийн эерэг үр дүн байв. 31 ажил олгогчийн 1473 ажлын байрыг танилцуулж, 152 оролцогч анкет бөглөж, 210 оролцогчийг ажлын ярилцлагад хамруулж, 73 оролцогч дадлагажих гэрээ байгуулсан бөгөөд мөн 7 аймгийн 322 ажил олгогчийн 991 ажлын байрыг танилцуулж, 56 оролцогчийг тухайн ажлын байруудад бүртгэсэн. Мөн оролцогч залуусын хувьд урт хугацааны ажилгүйдэлд өртсөн, ажилд ороход хүндрэлтэй иргэдийн төлөөлөл их байсан. Төсөлд хамрагдсан оролцогчдын хоорондын харилцаа, хандлага нэмэгдэж, нийгэмд эзлэх байр суурь, өөртөө итгэх итгэлтэй болж байна. Залуучуудад хувь хүний хөгжил, эх оронч үзэл, эрүүл, зөв амьдралын хэв маягийг эзэмших чадварыг сургалт, өдөр тутмын үйл ажиллагаагаар олгож байна.<br>Оролцогч залуучууд хамт олны дунд биеэ зөв авч явах, хүсэл мөрөөдөлдөө хэрхэн хүрэх, ажил хөдөлмөр эрхлэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж байгаа зэрэг зэрэг үр дүн гарч байна. | |
| 43 | | 3.1.18. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ. | 2020 - 2050 | - | “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”- батлуулсан байна.<br>-Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэсэн байна. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны А/127, А/333 дугаар тушаалаар “Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний загварыг турших 2022-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулав. | 30 |
| 44 | 3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг | 3.3.1. Аймаг, сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес | 2020 - 2050 | 1.6 тэрбум ХЭДС | Ажлын хэсэг | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор 2022 онд хэрэгжүүлэхээр “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | эрхлэгчдийг санхүүгийн болон зах зээлтэй холбох, өртгийн сүлжээний кластер байгуулж зохион байгуулалттай ажлын байр бий болгох төслүүдийг улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбоно. | | | | хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” зэрэг хөтөлбөрүүдийг шинэчлэн баталсан.<br>Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ, Малчдыг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох, Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад санхүүгийн дэмжлэг олгох, Аж ахуй, өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгохоор хөтөлбөрт тусган ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 2022 оны 12 сарын байдлаар нийт 9095 иргэн хамрагдаж 18.2 тэрбум төгрөг зарцуулж 3767 ажлын байр бий болсон байна. Хөтөлбөрийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:<br>• Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2032 иргэн хамрагдаж, 2263 ажлын байр бий болж, 13.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.<br>• Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах арга хэмжээнд 3618 иргэн хамрагдаж, 68.4 сая төгрөгийн санхүүжилт гарсан байна.<br>• Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 702 өрхийн 1704 иргэн хамрагдаж, 1452 ажлын байр бий болж, 3.8 тэрбум төгрөгийг;<br>• Гэрээт малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 14 өрхийн 28 иргэн хамрагдаж 52.3 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>• Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт зохион байгуулах арга хэмжээнд 492 өрхийн 624 иргэн хамрагдаж 20.4 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>• Борлуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 915 иргэн хамрагдаж 190.5 сая төгрөгийг;<br>• Түрээсийн дэмжлэг олгох арга хэмжээнд 142 иргэн хамрагдаж, 160.9 сая төгрөгийг зарцуулсан<br>• Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний урамшуулалд 20 ажил олгогч, 30 иргэн хамрагдаж, 14 ажлын байр бий болж 150.9 сая төгрөгийг;<br>Санхүүгийн дэмжлэг /цалингийн дэмжлэг/ арга хэмжээнд 2 ажил олгогч хамрагдаж 10,1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. | |
| 45 | | 3.3.6. Салбарын тогтвортой хөгжлийг хангахад шаардлагатай мэдээллийн сан бүхий мэдээллийн системийг бий болгоно. | 2020 - 2050 | 1,500.0<br>Дэлхийн банк | 453.0 | Дэлхийн банкны “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Хөдөлмөр эрхлэлтийн цахим систем “Ejob” платформыг нэвтрүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/126 дугаар тушаалаар ажлын хэсэг, дэд ажлын хэсгийг байгуулан харьяа агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагууд, холбогдох бусад байгууллагын төлөөллийг оролцуулан нийт 32 удаагийн уулзалтыг зохион байгуулж ажилласан.<br>“Ejob” платформ нь 3 дэд систем 13 модулиас бүрдсэн. Шинэ систем нь “ХУР”, “ДАН” зэрэг төрийн бусад мэдээллийн системтэй холбогдож, хэрэглэгч бүрийн хэрэгцээнд тохируулан хөгжүүлж, хүндрэл бэрхшээлийг технологийн шийдлээр оновчтой шийдвэрлэхээр зорьсон болно. Уг системийг 21 аймаг, 9 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүүргийн сум, хороодын түвшинд ажил хайгчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын хүний нөөцийн 1 сая гаруй хэрэглэгч ашиглах юм.<br>“Ejob” платформыг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ашиглалтад оруууллаа.<br>Энэхүү ажлын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 21 аймаг, 9 дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн нийт 301 албан хаагчдыг хамруулсан сургагч багш бэлтгэх сургалтыг Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан. Системийн эхний модуль буюу онлайн порталыг ашиглалтад оруулснаар ажил хайх, ажил санал болгох үйл ажиллагааг уламжлалт арга барил буюу хувь хүний мэргэжил, боловсролд илүү тулгуурлан зуучилдаг байсан бол шинэ системд ажилд зуучлах алгоритм үүсгэж ажил хайгчдын ажлын туршлага, ур чадвар, чадамжийг харгалзан хүний оролцоогүйгээр системийн тусламжтайгаар ажилд зуучлах давуу талтай болж байна. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн боловсролгүй, дипломгүй ч гэсэн ажил хөдөлмөр хийж байсан туршлага, ур чадвартай бол ажилд санал болгох боломжийг нээж өгч байгаа юм. | |
| 46 | | 3.3.12. Хүн амын бүтээлч санаачилга, хандлага, ур чадвар, зан үйл болон үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | 17.5 тэрбум<br><br>Төслийн зүгээс профайлингийн үйлчилгээг Төрийн болон Хувийн хөдөлмөр эрхлэлтийн албадад нутагшуулах ажлын хүрээнд 2022 онд нийт 125.000 Ам Долларыг зарцуулахаар төлөвлөн<br><br>Европын Холбооны санхүүжилтээр НҮБХХ-ийн “Тогтвортой хөгжлийн | 5000 хүн<br><br>50000 хүн | Монгол Улсын нийт хүн амын 31 хувь, хөдөлмөрийн насны хүн амын 46 хувийг бүрдүүлдэг 15-34 насны залуучуудад хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхлыг бий болгох, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх замаар хөдөлмөрт бэлтгэж, ажилтай орлоготой болгох зорилгоор БХЯ-тай хамтран Залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх “Оролцоо” төслийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь ажил, хөдөлмөр эрхлэх, амьдралаа өөрчлөх хүсэл мөрөөдөлтэй залуучуудыг сонгон шалгаруулсны үндсэн дээр тус бүр 14 хоногийн вакумжуулсан сургалт болон 14 хоногийн ажлын байран дээрх дадлагад хамруулан тус бүр 1.0 сая төгрөгийн тэтгэлгийг олгох юм. 2022 онд “Оролцоо” төслийг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/47 дугаар тушаалаар байгуулж, Төслийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон Батлан хамгаалахын сайд нарын хамтарсан тушаалаар баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Төслийг 2022 оны 06 сарын 09-ний өдрөөс эхлүүлэн нийт 12 ээлжээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, ээлжийн хуваарь батлуулав. Төсөлд хамрагдах залуучуудын бүртгэлийн үйл ажиллагааг 2022 оны 05 сарын 16-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд www.e-mongolia.mn цахим системээр бүртгэн, сонгон шалгаруулалтыг зохион байгууллаа.<br>Төслийн нэгдүгээр ээлжинд 238 оролцогчтойгоор Зэвсэгт хүчний 119 дүгээр анги дахь төслийн хотхонд эхэлсэн бол төслийн хоёрдугаар ээлж 308 оролцогч, төслийн гуравдугаар ээлж 233 оролцогч, төслийн дөрөвдүгээр ээлжинд 21 аймаг, 9 дүүргийн 451 оролцогчтойгоор тайлант хугацааны байдлаар нийт 1230 залуус Олон улсын Найрамдал цогцолборт хамрагдаад байна.<br>Мөн тус яам нь "Тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг шинэчлэх нь" төслийн багтай хамтран "Профайлинг" буюу ажилгүй иргэдийн хөдөлмөрлөх ур чадварыг үнэлэх, дутагдалтай ур чадваруудыг илрүүлж, тухайн хүнд тохирсон "Хувь хүний хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө"-г гарган хэрэгжүүлдэг гадаад улсын туршлагыг нэвтрүүлж, 2022-2023 онд 50000 иргэнийг хамруулахаар | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслөөс санхүүжүүлж байна. | | төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.<br>2022 оны 4-7 сарын хугацаанд төрийн болон хувийн хөдөлмөр эрхлэлтийн албаны нийт 515 мэргэжилтнийг Профайлинг аргазүйн сургалтад хамруулж, чадавх бэхжүүлэх сургалтад хамруулсан.<br>2022 оны 5 сараас хойш Профайлингийн үйлчилгээг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрт хамрагдаж буй иргэд болон оролцоо төсөлд хамрагдаж буй залуус буюу нийт 10,000 гаруй иргэдэд үнэлгээ хийж Профайлингийн ажлын явцад хяналт хийж, цаашид хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлох зорилгоор ХНХЯ, төслийн нэгжээс бүрдсэн баг 6, 7-р сард аймаг, дүүргүүдэд ажилласан. | |
| 47 | | 3.3.13. "Залуу энтрепренершип" үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2020 - 2050 | 780.0 сая | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр 1800 хүн | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ыг баталсан. Хөтөлбөрийн 4.1-т аймаг дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагуудтай хамтран ажил хайгч, залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх, 4.2-т мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахаар болсон. Дээрх арга хэмжээд 2022-2023 онд 780.0 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн.<br>2022 оны 12 дугаар сарын байдлаар 536.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. | 70 |
| 48 | | 3.3.14. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. | 2020 - 2050 | 800.0 сая төгрөг | 75 хүн | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт " Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ын баталсан. Хөтөлбөрийн 4.3-т шинэ технологи инноваци бүхий шинэлэг санал, санаачлаг гаргаж, аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг "Старт-Ап" залуу, залуучуудын багийг шалгаруулж, эргэн төлөх нөхцөлгүйгээр 10 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг олгохоор заасан.<br>2022 оны 12 дугаар сарын байдлаар Гарааны бизнесийг дэмжих арга хэмжээнд нийт 295 багийн 690 иргэн хамрагдаж 155.5 сая төгрөг зарцуулсан бол, Гарааны санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 25 багийн 48 иргэн хамрагдаж 245.0 сая төгрөг зарцуулж нийт 50 ажлын байр бий болсон байна. | 100 |
| 49 | | 3.3.15. Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ. | 2020 - 2050 | Төсөл 2019-2021 оны 12 сард дууссан | 21 аймаг, 9 дүүрэг, нийслэлийн загвар төв | Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төвийг улсын хэмжээнд буюу 21 аймаг, 9 дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүд болон Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын дэргэд тус тус шинээр байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн шинэлэг үйлчилгээг залуучуудад хүргэн ажиллаж байна. Тус төв нь гарааны бизнес эрхлэх зөвлөгөө үйлчилгээ, бизнес сэтгэлгээ буюу энтерпренершип, үйл ажиллагаа явуулж буй залуучуудын жижиг дунд, үйлчилгээнд арга зүй, зөвлөгөө мэдээллийн чиглэлээр дэмжлэг үзүүлж байна. | 100 |

| Долоо. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 50 | 7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлнэ. | 7.3.7. Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг нийгмийн байгууллага, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ. | 2020 - 2050 | 99,4 сая вон | Сургалт зохион байгуулах: /Цагдаагийн байцаагч-30 Хүүхэд хамгааллын ажилтан - 30 Хилийн хяналтын офицер - 30 Эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд – 30/ - Удирдамжийн практик хэрэглээг дэмжих; - Удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих; | 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс БНСУ-ын Гэр бүл, Жендэрийн эрх тэгш яамтай хамтран “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх үйлчилгээг бэхжүүлэх” төслийг 5 жилийн хугацаатай 750 000 USD(долоон зуун тавин мянган ам доллар)-ын санхүүжилттэй хэрэгжүүлж байна. Төслийн гол зорилго нь Монгол Улсад хүний эрхийг хамгаалах, эмэгтэйчүүд, охидыг эргэн нийгэмшүүлэх, эдийн засгийн хувьд нөхөн сэргээх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.<br>Энэхүү төслийг мэргэжлийн төрийн бус байгууллага болох Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд Хүйсийн тэгш эрх төвд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгт 2020 онд 46 хохирогч, 2021 онд 41 хохирогч, 2022 оны 11 сарын байдлаар 45 хохирогч хандаж анхан шатны (хамгаалах байрны үйлчилгээ, гадаад оронд хүний найманы хохирогч болсон Монгол Улсын иргэдийг эх нутаг нь эгүүлэн авчрах, эрүүл мэнд, хоол хүнс, нэг удаагийн хувцас, ахуйн хэрэглээний үйлчилгээ, хууль зүйн туслалцаа болон сэтгэл зүйн зөвлөгөө өгөх гэх) болон нөхөн сэргээх (сэтгэл засал, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, өмгөөллийн туслалцаа, гэр бүлд нэгтгэх, ажил зуучлах, гэх) үйлчилгээнд хамрагдсан байна. Үүнээс 10 хохирогчийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, хамгаалах байрны үйлчилгээ, 41 хүнд сэтгэл зүй, хууль зүйн анхан шатны туслалцаа, хоол хүнс, хувцас, ахуйн хэрэглээний туслалцаа үзүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 80,0 сая | Эмэгтэйчүүдийг бэлгийн дарамтад өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээний төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | - Зорилтот 4 бүлгийн (нийгмийн ажилтан, хууль сахиулах, зочид буудлын үйлчилгээний ажилтан нар) 2714 мэргэжилтнүүдэд хүн худалдаалах гэмт хэрэг, жендэрт суурилсан хүчирхийлэл, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах талаарх мэдээлэл;<br>- Мөн зорилтот бүлгийн 714 хүнийг сургалтад;<br>- Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 ном<br>- 1 плакатыг 3300 ширхэг хэвлүүлж, олон нийтэд түгээгээд байна.<br>- Олон нийтэд мэдээлэл өгөх компанит ажлыг **(Street company)** Эрүүгийн Цагдаагийн албатай хамтран Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Улаанбаатар хотод зохион байгуулж, эцэг эхчүүд болон хүүхдүүдэд хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл өглөө.<br>- Хүн худалдаалах хохирогчийг таних, илрүүлэх зааврыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>“Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх үйлчилгээг бэхжүүлэх” төслийн төлөвлөгөөг жил бүр БНСУ-ын Гэр бүл, Жендэрийн эрх тэгш яамтай хамтран баталдаг. | |
| 51 | 7.3. Уламжлалт бус аюулын эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, хүн-нийгмийн амар тайван орчныг бэхжүүлнэ. | 7.3.11. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна. | 2020 - 2050 | 138,7 сая төг | ТХБ, НЦҮТ-ийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна. | Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах чиглэлээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТБ-ын дэргэд 2008 онд 2 түр хамгаалах байр ажиллаж байсан бол 2022 оны байдлаар 16 Нэг цэгийн үйлчилгээний төв, 18 Түр хамгаалах байр 4 байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс нийслэлийн хэмжээнд нийт 11, /БГД-3, БЗД-2, СБД-2, ЧД-1, ХУД-2, Налайх-1/, орон нутагт нийт-22 /Сэлэнгэ-2 Дорноговь-2/ Дундговь аймагт түр хамгаалах байр байхгүй байна.<br>Цагдаагийн байгууллагад **2022** оны эхний **10** сард гэмт хэрэг, зөрчлийн 257,038 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасанаас **31,769** буюу **12,4** хувь нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн бол гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн **55,3** хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна. 2022 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 34 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна. 17 Түр хамгаалах байр, 17 Нэг цэгийн үйлчилгээний төвд нийт **3988** иргэн түр хамгаалан байрлуулах үйлчилгээг авсан байна. Үүнээс **1299** насанд хүрэгч, **2699** хүүхэд байна. Нийт үйлчилгээ авсан хүүхдийн 116 нь 2-оос дээш удаа түр хамгаалах байранд ирсэн байна. Гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 1757, асрамж, халамжийн үйлчилгээнд 82, дэмжих, холбон зуучлах үйлчилгээг 860 хүүхдэд үзүүлж, аюулгүй байдлыг ханган ажилласан. | 100 |
| | | | | | | **Нийт арга хэмжээний хэрэгжилт** | **83.1** |

| № | Шалгуур үзүүлэлт[2] | Хэмжих нэгж[3] | Суурь түвшин[4] | | Зорилтот түвшин[5] | | Тайлант хугацааны хүрсэн түвшин[6] | Шалгуур үзүүлэлтийн тайлбар[7] | Мэдээлэл цуглуулах арга зүй, эх үүсвэр[8] | Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)[9] | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Он | Түвшин | Он | Түвшин | | | | | |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 4 | Хүний хөгжлийн үзүүлэлт | индекс | 0.74 | 0.77 | 0.85 | 0.9 | **2020 оны байдлаар ХХИ 0.774** | Үндэсний статистикийн хороо | Статистик мэдээ | Жилд нэг удаа | Үндэсний статистикийн хороо |
| 9 | Нийт төгсөгчид ажил эрхэлж байгаа төгсөгчдийнэзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль) | хувь | 76.5 | 90 | 95 | 100 | 2021 оны 7 сарын байдлаар 51.5% | Мэргэжлийн боловсрол, сургалтын төв | Статистик мэдээ | Жилд нэг удаа | Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 11 | Хүн амын дундаж наслалт | жил | 70.2 | 74 | 78 | 82 | **2020 оны байдлаар дундаж наслалт 70.71** | Үндэсний статистикийн хороо | Статистик мэдээ | Жилд нэг удаа | Үндэсний статистикийн хороо |
| 21 | Дундаж ба түүнээс дээш давхаргын иргэдийн эзлэх хувь | хувь | 71.6 | 80 | 85 | 95 | Үндэсний статистикийн хороо гаргана | Үндэсний статистикийн хороо | Салбарын тайлан | 2 жилд нэг удаа | Үндэсний статистикийн хороо |
| 22 | Ядуурлын түвшин | хувь | 28.4 | 20 | 15 | 5 | **2020 оны тоо 1212.mn дээр байршуулаагүй байна.** | Үндэсний статистикийн хороо | Салбарын тайлан | 2 жилд нэг удаа | Үндэсний статистикийн хороо |
| 26 | Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдсан хувь | хувь | 2020 | 84.4 | 2025 | 90 | 94.2 | 2022 оны жилийн байдлаар ажиллах хүчний 94,2 %-ийг нийгмийн даатгалд хамруулсан байна. | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, ҮСХ-ны 1212.mn сайт | Зорилтод түвшний үзүүлэлт жилд нэг удаа гардаг. | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| 27 | Ажиллах хүчний оролцооны түвшин | хувь | 61 | 63 | 65 | 70 | 2021 оны 2 улирал-56,8 хувь | Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа | Үндэсний хэмжээний түүвэр судалгаа | Улирал бүр | Үндэсний статистикийн хороо |
| 28 | Ажилгүйдлийн түвшин | хувь | 8.6 | 7.8 | 7 | 3 | Ажиллах хүчний судалгаа 2021 он 2021 оны 21-р улирлын байдлаар 8.4% | Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа | Үндэсний хэмжээний түүвэр судалгаа | Улирал бүр | Үндэсний статистикийн хороо |